

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2025 оны III улирлын санхүүгийн тайлан

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР
Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV
байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР

Агуулга

Хүснэгтийн жагсаалт	3
Зургийн жагсаалт	3
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН.....	4
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	5
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	6
Батлан даалт, байршил.....	7
Батлан даалт, зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэл.....	8
Зээлдүүлэгч болон батлан даалтын эх үүсвэр	9
Зээлийн болон батлан даалтын чанар	10
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	12
САНАЛ, ДҮГНЭЛТ	13

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Батлан даалтын хүсэлтийн тоо	6
Хүснэгт 2 Зээл, батлан даалтын дүн, тоо (дүүргээр).....	7
Хүснэгт 3 Зээл, батлан даалтын дүн, тоо (аймгаар)	8
Хүснэгт 4 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт	12

Зургийн жагсаалт

Зураг 1 Нийт хөрөнгө (тэр.төг).....	5
Зураг 2 Эх үүсвэрийн бүтэц (хувиар).....	5
Зураг 3 Нийт орлого, цэвэр ашиг (тэр.төг).....	5
Зураг 4 Нийт орлого, зардал (тэр.төг).....	5
Зураг 5 Зээл, батлан даалтын үлдэгдэл (тэр.төг)	6
Зураг 6 Зээл, батлан даалтын дүн (тэр.төг)	6
Зураг 7 Батлан даалтын дүн, тоо (бүс нутгаар).....	7
Зураг 8 Батлан даалтын бүтэц (үйл ажиллагааны чиглэлээр)	8
Зураг 9 Батлан даалтын хэмжээ (банкаар).....	9
Зураг 10 Батлан даалтын бүтэц (эх үүсвэрээр)	9
Зураг 11 Зээлийн чанар (хувиар)	
Зураг 12 Батлан даалтын чанар (хувиар)	10
Зураг 13 Чанаргүй батлан даалтын хувь, зээлдэгчдийн тоо	10
Зураг 14 Үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын дүн, тоо	11

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Зээлийн батлан даалтын сан байгуулагдсан. Зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

Засгийн газраас хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 2021 онд Улсын Их Хурлаас тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 9 дүгээр зүйлийн 9.1.3-т “төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах” гэж заасан. Үүний дагуу 2023 оноос эхлэн 21 аймаг болон Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд банк, санхүүгийн байгууллагаас орон сууцны ипотекийн 6 хувийн хүүтэй зээл авахыг хүссэн, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн дутагдалтай этгээдэд урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргаж эхэлсэн.


Мөн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т “уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 100 хүртэлх хувьд батлан даалт гаргах.” гэж нэмсэн.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд 3 заалтыг өөрчлөн найруулахаар, 9 заалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ ирүүлсэн ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлээр Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ


2025 оны III улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 310.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.3 хувиар буюу 779.7 сая төгрөгөөр буурсан ба үүнд хөрөнгө оруулалт ба үндсэн хөрөнгийн бууралт голлон нөлөөлж байна.

Зураг 1 Нийт хөрөнгө (тэр.төг)




Тайлант үеийн Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг бүтцээр нь задалж үзвэл 64.7 хувийг өр төлбөр, 35.3 хувийг цэвэр хөрөнгө бүрдүүлж байна. Нийт өр төлбөрийн 2.1 хувь нь богино хугацаат өр төлбөр бол үлдсэн 97.9 хувь нь урт хугацаат зээл, урт хугацаат зээлийн хүүгийн өглөг байна.

Зураг 2 Эх үүсвэрийн бүтэц (хувиар)




Тайлант үеийн нийт орлого 19.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар буюу 2.5 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм. Харин цэвэр ашгийн хэмжээ (2.7) тэрбум төгрөгийг өмнөх оны дүнтэй харьцуулахад 3.6 дахин бага буюу 17.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 3 Нийт орлого, цэвэр ашиг (тэр.төг)



Нийт орлогын 90 хувийг хадгаламжийн хүүгийн орлого, 10 хувийг батлан даалтын шимтгэлийн орлого бүрдүүлж байгаа бол нийт зардлын 56.5 хувийг цалин хөлс, шагналын зардал, 42.6 хувийг засвар үйлчилгээний зардал, 0.9 хувийг НДШ, ЭМД-ын шимтгэлийн болон бусад зардал тус тус эзэлж байна.


Зураг 4 Нийт орлого, зардал (тэр.төг)



ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 оны III улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сантай 11 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллах гэрээтэй бөгөөд тайлант хугацаанд нэр бүхий 8 банкны 1,818 зээлдэгчдэд 56.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.

Зураг 5 Зээл, батлан даалтын үлдэгдэл (тэр.төг)



Тайлант үеийн нийт батлан даасан зээлийн үлдэгдэл 805.5 тэрбум төгрөг байгаа нь 2024 оны мөн үеэс 19.6 хувиар, батлан даалтын үлдэгдэл 448.6 тэрбум төгрөг байгаа нь 16.6 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт зээлийн үлдэгдлийн 55.7 хувийг Сангаас батлан даасан байна.


Энэ оны III улирлын байдлаар батлан даалтын нийт 15,230 хүсэлт ирүүлснийг 100 хувь батлан даах шийдвэр гаргаснаас тайлант хугацаанд 1,818 зээлдэгчийн зээл олгогдож, батлан даалт нь гарсан байна. 2025 оны III улирлын байдлаар ирүүлсэн хүсэлтийн тоо нь 2024 оны мөн үеэс 5.9 дахин буурсан байгаа нь Монгол Улсын Засгийн газраас баталсан “Төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлого” болон “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд батлан даалт гаргуулах сонирхолтой иргэдийн хүсэлт голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1 Батлан даалтын хүсэлтийн тоо

Батлан даалтын хүсэлт	2021.III	2022.III	2023.III	2024.III	2025.III
Ирүүлсэн хүсэлтийн тоо	319	56	202	10,775	1,818
Зөвшөөрөгдсөн хүсэлтийн тоо	236	31	155	10,774	1,818
Эзлэх хувь	74%	55%	77%	99.99%	100%

2025 оны III улирлын байдлаар нийт 1,818 зээлдэгчийн 113.7 тэрбум төгрөгийн зээлд 56.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь 2024 оны мөн үеэс 2 дахин өссөн дүн юм. Нэг батлан даалтын дундаж хэмжээг тооцвол 2025 оны III улирлын байдлаар 31.1 сая байгаа нь өмнөх 4 жилийн дундажтай харьцуулахад 6 дахин бага дүн юм. Үүнд хоршооны гишүүн малчдад гаргасан батлан даалт голлон нөлөөлж байгаа ба нэг малчинд олгосон дундаж зээлийн хэмжээ 33.3 сая, батлан даалтын дүн 22.8 сая байна.

Зураг 6 Нэг батлан даалтын дундаж хэмжээ (сая.төг)



Тайлант үеийн хугацаанд Улаанбаатар хотын 26 зээлдэгчийн 18.5 тэрбум төгрөгийн зээлд 8.8 тэрбум төгрөгийн, орон нутгийн 1,792 зээлдэгчийн 95.2 тэрбум төгрөгийн зээлд 47.9 тэрбум төгрөгийн батлан даалт тус тус гаргасан байна.

Батлан даалт, байршил

2025 оны III улирлын байдлаар нийслэлийн дараах 6 дүүрэгт батлан даалт гаргасан ба Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их буюу 2.3 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний батлан даалт гаргасан бол Налайх дүүрэгт хамгийн бага буюу 21.6 сая төгрөгийн батлан даалт гаргажээ. Нийслэлийн 26 зээлдэгчийн 17 зээлдэгч нь Азийн хөгжлийн банкны төслийн зээл авсан иргэд, 4 зээлдэгч нь бөөний болон жижиглэн худалдаа эрхлэгчид бол үлдсэн 5 зээлдэгч нь боловсруулах үйлдвэрлэл чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд болон хувь хүмүүс байна.

Хүснэгт 2 Зээл, батлан даалтын дүн, тоо (дүүргээр)

Дүүрэг	Зээлийн дүн /сая.төг/	Батлан даалтын дүн /сая.төг/	Батлан даалтын тоо
Баянгол	4,240.0	1,918.1	4
Баянзүрх	5,155.0	2,381.3	7
Налайх	105.6	21.6	1
Сонгинохайрхан	5,158.0	2,366.0	8
Хан-Уул	3,130.0	1,651.8	5
Чингэлтэй	700.0	420.0	1
Улаанбаатар	18.5	8.8	26

Тайлант хугацаанд гаргасан батлан даалтыг бүс нутгаар задалж үзвэл хангайн бүсэд хамгийн их буюу 1,207 зээлдэгчийн 57 тэрбум төгрөгийн зээлд 30.4 тэрбум төгрөгийн батлан даалт, төвийн бүсэд хамгийн бага буюу 182 зээлдэгчийн 13.6 тэрбум төгрөгийн зээлд 5.9 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. Орон нутагт гаргасан нийт батлан даалтын дүнгийн 15.7 хувь нь хуулийн этгээдэд, үлдсэн 84.3 хувь нь иргэдэд гаргасан батлан даалт байна.

Зураг 7 Батлан даалтын хэмжээ, тоо (бүс нутгаар)



Батлан даалтад хамрагдсан орон нутгийн 1,792 зээлдэгчийн 47.8 тэрбум төгрөгийн батлан даалтын 35.3 тэрбум төгрөг нь 1,543 зээлдэгчийн “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий малчдын зээлд, 8.1 тэрбум төгрөг нь 218 зээлдэгчийн ипотекийн зээлд, 8.1 тэрбум төгрөг нь 31 хуулийн этгээдийн бизнесийн зээлд гаргасан батлан даалт байна.

Хүснэгт 3 Зээл, батлан даалтын дүн, тоо (аймгаар)

Аймаг	Зээлийн дүн /сая.төг/	Батлан даалтын дүн /сая.төг/	Батлан даалтын тоо
Архангай аймаг	6,935.3	4,461.2	190
Баян-Өлгий аймаг	65.0	30.0	2
Баянхонгор аймаг	16,595.0	11,483.1	481
Булган аймаг	7,749.5	4,197.7	150
Говь-Алтай аймаг	3,700.4	1,771.1	86
Говьсүмбэр аймаг	50.0	40.0	1
Дархан-Уул аймаг	3,227.2	1,467.5	13
Дорноговь аймаг	1,679.3	455.6	19
Дорнод аймаг	8,595.0	2,893.6	73
Дундговь аймаг	2,202.8	1,227.0	56
Завхан аймаг	1,767.0	1,048.9	58
Орхон аймаг	11,302.3	2,768.7	70
Өвөрхангай аймаг	3,497.7	1,407.8	36
Өмнөговь аймаг	1,715.4	695.3	17
Сүхбаатар аймаг	1,381.0	309.7	14
Сэлэнгэ аймаг	2,628.2	965.5	30
Төв аймаг	2,107.7	1,087.7	46
Увс аймаг	1,629.6	732.0	37
Ховд аймаг	337.0	157.4	5
Хөвсгөл аймаг	10,949.4	6,110.8	280
Хэнтий аймаг	7,102.2	4,559.5	128
Нийт	95,217.0	47,870.1	1,792

Батлан даалт, зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэл

2025 оны III байдлаар нийт гаргасан батлан даалтын 62.3 хувийг Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий малчид, 12.5 хувийг бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа, 5.9 хувийг боловсруулах үйлдвэр, 4.0 хувийг эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, үлдсэн 15.2 хувийг бусад салбар тус тус эзэлж байна.

Зураг 8 Батлан даалтын бүтэц (үйл ажиллагааны чиглэлээр)

Шинэ хоршоо
хөдөлгөөний малчид



62.3%

Бөөний болон
жижиглэн худалдаа



12.5%

Боловсруулах
үйлдвэр



5.9%



4.0%




15.2%

Зээлдүүлэгч болон батлан даалтын эх үүсвэр


Тайлант хугацаанд доорх 8 арилжааны банкны зээлд батлан даалт гаргасан ба Хаан банкны 60.3 тэрбум төгрөгийн зээлд 34.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь нийт батлан даалтын 61.0 хувийг эзэлж байна. Төрийн банкны 15.2 тэрбум төгрөгийн зээлд 8.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь нийт батлан даалтын 15.1 хувийг эзэлж, Худалдаа хөгжлийн банкны 19.3 тэрбум төгрөгийн зээлд 6.7 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь нийт батлан даалтын 11.8 хувийг эзэлж, Голомт банкны 8.5 тэрбум төгрөгийн зээлд 3.1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь нийт батлан даалтын 5.5 хувийг эзэлж байна. Харин Богд банк, Голомт банк, Хас банк, Ариг банк зэрэг санхүүгийн байгууллагуудын 10.4 тэрбум төгрөгийн зээлд 3.7 тэрбум төгрөгийн батлан даалт тус тус гаргасан байна. Хамгийн их батлан даалттай зээл олгосон Хаан банкны хувьд хоршооны гишүүн малчдад олгосон зээлийн батлан даалтын хэмжээ 28 тэрбум төгрөг байгаа нь тухайн банканд гаргасан батлан даалтын 80.9 хувийг эзэлж байна.

Зураг 9 Батлан даалтын хэмжээ (банкаар)



Эх үүсвэрийн хувьд авч үзвэл тайлант үеийн хугацаанд гарсан нийт батлан даалтын 77.9 хувь буюу 238.6 тэрбум төгрөгийг “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бол 13.7 хувийг Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл, 6.6 хувийг ипотека, үлдсэн 1.8 хувийг Азийн хөгжлийн банк-Эмэгтэй бизнес, Жайка, Ногоон зээл, ХХААДЗ зэрэг бусад эх үүсвэрээс тус тус санхүүжүүлжээ.


Зураг 10 Батлан даалтын бүтэц (эх үүсвэрээр)




Зээлийн болон батлан даалтын чанар

Батлан даасан нийт зээлийн үлдэгдлийг харвал нийт 15,066 зээлдэгчийн 772 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд байгаа нь нийт зээлийн багцын 95.8 хувийг эзэлж байна. Ангилал буурсан зээлийн хувьд 112 зээлдэгчийн 16.4 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 52 зээлдэгчийн 17.1 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн хувьд нэг зээлдэгчийн хугацаа хэтэрсэн дундаж хэмжээ 330 сая төгрөг байна. Харин Батлан даалтын чанарыг харвал 15,059 зээлдэгчийн 429 тэрбум төгрөгийн батлан даалт хэвийн, 122 зээлдэгчийн 9.7 тэрбум төгрөгийн батлан даалт хугацаа хэтэрсэн, 49 зээлдэгчийн 9.8 тэрбум төгрөгийн батлан даалт чанаргүй ангилалд байна.

Зураг 11 Зээлийн чанар (хувиар)




Зураг 12 Батлан даалтын чанар (хувиар)




2025 оны III улирлын байдлаар нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хэмжээ 2.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 пунктээр буюу 2.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Энэ улирлын нийт чанаргүй батлан даалтын тоо буурсан хэдий ч нийт батлан даалтын хэмжээ буурсны улмаас нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хувь өссөн гэж харагдаж байна. Мөн чанаргүй батлан даалтын тоо жилээс жилд буурсаар байгаа нь батлан даалтын чанарт сайнаар нөлөөлж байна.

Зураг 13 Чанаргүй батлан даалтын хувь, зээлдэгчдийн тоо



Тайлант хугацаанд зээлдүүлэгчдээс чанаргүй 57 зээлийн үүргийг хангуулахаар 7.5 тэрбум төгрөгийг нэхэмжилсэн ба Зээлийн батлан даалтын сангаас 6.9 тэрбум төгрөгийн үүргийг гүйцэтгэж, эргээд 42 зээлдэгчээс 1.7 тэрбум төгрөгийн авлагыг төлүүлсэн байна. Батлан даалтын үүргийн гүйцэтгэлийн сүүлийн 5 жилийн статистикийг харвал зээлдүүлэгчдээс нэхэмжилсэн дүн, гүйцэтгэсэн батлан даалтын дүн дунджаар 65-75 хувиар нэмэгдсээр байна.

Зураг 14 Үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын дүн (тэр.төг), тоо



ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу Сан нь дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллахаар зохицуулсан байдаг. Үүний дагуу 2025 оны эхний хагас жилийн тайлангаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг харвал нийт 13 шалгуур үзүүлэлтээс 12 үзүүлэлтийг хангасан бол үйл ажилгааны зардлын зохистой харьцааг хангаагүй байна. 2025 оны хагас жилийн тайлангийн үеэр 14.1% байсан харьцаа нь энэ улирлын байдлаар 19.9% болж өссөн нь ерөнхий удирдлагын зардал 21.8 тэрбум төгрөгт хүрч ихсэж үндсэн үйл ажиллагааны орлого 19.1 тэрбум болж буурсантай холбоотой байна.

Хүснэгт 4 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Өөрийн хөрөнгийн байвал доод хэмжээ	5,000,000,000.00	109,546,450,208.74	Хангасан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	10%-аас доошгүй	35.3%	Хангасан
Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй	448,570,972,141.03	Хангасан
ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	100%-аас доошгүй	130%	Хангасан
АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	60.0%	Хангасан
Хоршооны гишүүн малчинд гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	100%-аас хэтрэхгүй	100%	Хангасан
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	1.1%	Хангасан
Өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
Урт хугацаат өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	19.9%	Хангаагүй
ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	1.5%	Хангасан
НӨӨЦИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ			
Нөөцийн сангийн хүрэлцээний үзүүлэлт	(1,336,048,602.53)	28,923,037,052.59	Хангасан
ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА			
Чанаргүй батлан даалтын үлдэгдлийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	2.2%	Хангасан

САНАЛ, ДҮГНЭЛТ

2025 оны III улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 310.5 тэрбум төгрөгт хүрч, 2024 оны мөн үеэс 0.3 хувиар буурсан бол нийт орлогын хэмжээ 19.1 тэрбум төгрөгт хүрлээ.

Тайлант үеийн хугацаанд шинээр 1,818 зээлдэгчийн 113.7 тэрбум төгрөгийн зээлд 56.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн тайлангаар нийт 15,230 зээлдэгчийн 805.5 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлд 448.6 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэл бүртгэсэн байна.

Тайлант үеийн хугацаанд Улаанбаатар хотын 26 зээлдэгчийн 18.5 тэрбум төгрөгийн зээлд 8.8 тэрбум төгрөгийн, орон нутгийн 1,792 зээлдэгчийн 95.2 тэрбум төгрөгийн зээлд 47.9 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан ба батлан даалтад хамрагдсан зээлдэгчдийн 97 хувь нь иргэн, 3 хувь нь хуулийн этгээд байна. Улаанбаатар хотын хувьд Сонгинохайрхан дүүрэгт хамгийн их буюу 8 зээлдэгчид 2,366.0 сая төгрөгийн батлан даалт гаргасан бол орон нутагт Баянхонгор аймагт хамгийн их буюу 481 зээлдэгчид 11,483.1 сая төгрөгийн батлан даалт гаргажээ.

Зээлийн батлан даалтын сангаас 2025 оны III улирлын байдлаар нэр бүхий 8 арилжааны банкны зээлд батлан даалт гаргасан ба хамгийн их батлан даалттай Хаан банкны хувьд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хоршооны гишүүн малчдад олгосон зээл тухайн банканд гаргасан батлан даалтын 94.9 хувийг эзэлж байна.

Тайлангийн хугацаанд шинээр гаргасан батлан даалтын 62.4 хувь буюу 35.3 тэрбум төгрөгийг “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд төрөөс төсвийн хөрөнгөөр, үлдсэн 31.3 хувийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна.

Нийт батлан даасан зээлийн чанарыг харвал 15,059 зээлдэгчийн 429 тэрбум төгрөгийн зээл хэвийн, 171 зээлдэгчийн 19.5 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн болон чанаргүй ангилалд шилжиж нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 4.1 хувь болж нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хувь 2.2 хувь болж өсжээ. Сүүлийн 5 жилийн батлан даалтын үүргийн гүйцэтгэлийн мэдээгээр зээлдүүлэгчдээс нэхэмжилсэн дүн, үүрэг гүйцэтгэсэн дүн дунджаар 65-75 хувиар нэмэгдэж байгаа тул зээлийн болон батлан даалтын чанарт онцгой анхаарах хэрэгтэй байна.

Шинээр батлан даасан зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэлийг харвал батлан даалтын 62.3 хувийг Хоршооны гишүүн малчид, 12.5 хувийг бөөний болон жижиглэн худалдааны бизнес эрхлэгчид, 5.9 хувийг боловсуулах үйлдвэр, 4.0 хувийг эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа, үлдсэн 15.2 хувийг бусад салбар тус тус эзэлж байгаа нь эдийн засгийн салбаруудад батлан даалтын хүртээмж жигд бус байгааг илтгэж байна. Тиймээс эдийн засгийн бусад салбарт тэр дундаа нэмүү өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдэд батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

2025 оны III улирлын тайлангаар Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон зохистой харьцааны 13 шалгуур үзүүлэлтээс 12 үзүүлэлтийг хангаж ажилласан боловч ерөнхий удирдлагын зардал ихсэж үндсэн үйл ажиллагааны орлого буурсантай холбоотой “Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа 15%-с хэтрэхгүй” гэсэн шалгуурыг хангаагүй тул холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

